

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ

ЗАСАГ ДАРГА, ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Ч.НАРАНБАТ

ГҮЙЦЭТГЭГЧ

“ЗОСТ-ӨРГӨӨ” ХХК  
ЗАХИРАЛ

Н.СҮРЭНЖАВ

УЛИАСТАЙ СУМЫН ӨЛЗИЙТ, ТОВЦОГ, ЖАРГАЛАНТ, ЧИГЭСТЭЙ,  
ЖИНСТ БАГУУДАД АВТОБУСНЫ БУУДАЛ БАРИХ АЖЛЫН  
ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ

2023-06-30

Дугаар №32/2023

Улиастай сум


Нэг талаас Улиастай сумын Засаг Даргын Тамгын Газар (цаашид “захиалагч” гэх), “Зост-Өргөө” ХХК захирал Н.Сүрэнжав (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 06 сарын 30-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу Улиастай сумын Өлзийт, Товцог, Жаргалант, Чигэстэй, Жинст багуудад автобусны буудал барих ажилтай холбогдох захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Улиастай сумын Өлзийт, Товцог, Жаргалант, Чигэстэй, Жинст багуудад автобусны буудал барих ажлыг (цаашид “бараа” гэх) **96.499.960 /ерин зургаан сая дөрвөн зуун ерин есөн мянга есөн зуун жаран/ төгрөгөөр** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгүүлэхээр харилцан зөвшөөрөв. Гүйцэтгэгчийн хийсэн ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгоно. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь ажлын гүйцэтгэгчийн **96.499.960 /ерин зургаан сая дөрвөн зуун ерин есөн мянга есөн зуун жаран/ төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Санхүүжилтийг ажил эхлэхээс өмнө урьдчилгаа 48.250.000 /дөчин найман сая хоёр зуун тавин мянга/, ажил үргэлжлэн хийгдэж байхад 29.000.000 /хорин есөн сая/, хийсэн ажлын гүйцэтгэлээр үлдсэн 19.249.960 /арван есөн сая хоёр зуун дөчин есөн мянга есөн зуун жаран/ төгрөгийг өгч 100% барагдуулна.**
4. Гүйцэтгэгч нь Улиастай сумын Өлзийт, Товцог, Жаргалант, Чигэстэй, Жинст багуудад автобусны буудал барих ажлыг 2023 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор гүйцэтгэж хүлээлгэж өгнө.

5. Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээж байна.
6. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн гүйцэтгэж хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дунг гэрээнд заасан хэлбэрээр гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
7. Гэрээнд заасны дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдэнэ. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгч биечлэн хүргэгдсэн эсхүл гэрээнд заасан хаягаар, илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцох ёстой.
8. Энэхүү гэрээтэй холбогdon талуудын хооронд үүсэх аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.
9. Тус гэрээнд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
10. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хавсралт, нэмэлт өөрчлөлт нь хууль зүйн ижил хүчинтэй байна.
11. Ажил хийгдэж дууссаны дараа гүйцэтгэлийн 14 хоногийн дотор захиалагчид хүлээлгэн өгнө.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ


Улиастай сумын Засаг  
Даргын Тамгын Газрын Архитектор  
Б.Нарангарав

Гарын үсэг: 

Утас: 99946611

Улиастай сумын Санхүү албаны  
дарга

Я.Дэлгэрмаа

Гарын үсэг: 

Утас: 94042196, 92930113

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

“Зост-Өргөө” ХХК  
Захирал  
Н.Сүрэнжав

Гарын үсэг: 

Завхан аймаг, Тосонцэнгэл сум

Банк: Хас банк

Данс: 5000231786

Утас: 99087426